



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/401

Арвайхээр

**Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай**

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны 143, 144 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Богд сумын 1 дүгээр цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдөр хүртэл, тус сумын 2 дугаар цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл, Арвайхээр сумын 12 дугаар цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2024 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүртэл тус бүр 5 жилийн хугацаатай олгосугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон дээрх байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100658